

Эрүүл Мэндийн Яам

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам

Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль

Буянжаргалын Өнөрбилэг

**МОНГОЛЧУУДЫН ШҮД, АМНЫ ХӨНДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
БОЛОВСРОЛ ОЛГОЖ БАЙСАН УЛАМЖЛАЛТ ЗАРИМ АРГУУД**

Е-723800 – Нүүр ам судлал

Ажлын удирдагч: Анагаах Ухааны Доктор, профессор

Н.Пүрэвжав

Ажлын зөвлөх: Анагаах Ухааны Доктор

Л.Мөнгөнцэцэг

Ажлын шүүмжлэгч: Шинжлэх Ухааны Доктор, профессор

Н.Бэгз

Анагаах Ухааны Магистрын зэрэг горилж бичсэн судалгааны

ажлын дэлгэрэнгүй

Улаанбаатар 2007 он.

ГАРЧИГ

Товчилсон үгийн жагсаалт	4
Нэг. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ	5
Хоёр. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО	8
Гурав. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛТ	9
Дөрөв. СУДАЛГААНЫ АЖЛЫН ШИНЭЛЭГ ТАЛ	9
Тав. СУДАЛГААНЫ АЖЛЫН ПРАКТИК АЧ ХОЛБОГДОЛ	9
Зургаа. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ ХЭЛЭЛЦҮҮЛСЭН БАЙДАЛ	10
Долоо. ХЭВЛЭЛИЙН ТОЙМ	11
Найм. СУДАЛГААНЫ АЖЛЫН БҮТЭЦ	24
Ес. СУДАЛГААНЫ АЖЛЫН МАТЕРИАЛ БА АРГА ЗҮЙ	25
Арав. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН	26
Арван нэг. СУДАЛГААНЫ АЖЛЫН ХЭЛЦЭМЖ	58
Арван хоёр. СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ	60
Ном зүй	62

Нэг. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ

“Нийгмийн гишүүдийн эрүүл мэнд бол нийгмийн баялгийн салшгүй хэсэг байдаг” гэсэн эдийн засгийн хэллэгээр нийгмийн эрүүл мэнд бол эд агуурсын төдийгүй оюуны үнэт зүйл (соёл)-ийг бүтээх нийгмийн чадавхи юм. Судлаачид нийгмийн эрүүл мэндийг бүрдүүлэгч хүчин зүйлийг дөрвөн үндсэн бүлэгт хувааж үздэг байна:

- Нийгмийн эдийн засгийн хүчин зүйлс – 15-20%
- Биологи удам зүйн хүчин зүйлс – 15-20%
- Эрүүл аж төрөх ёсны хүчин зүйлс (хүнээс өөрөөс нь шалтгаалах) – 50%
- Эрүүл мэндийн байгууллагын болон эмнэлгийн үйлчилгээний хүчин зүйлс – 10-15% тус тус эзлэнэ гэж Оросын нийгмийн эрүүл ахуйч нэрт эрдэмтэн Ю.П.Лысицин тэмдэглэжээ [27].

Дээрхи баримтаас харахад хүний эрүүл явах эсэх нь түүний хичээл зүтгэл, аж төрөх ёсоо хэрхэн зохицуулж чадсанаас шалтгаалдаг болох нь харагдаж байна. Тэгвэл хүн амд аж төрөх ёс, ялангуяа эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх үндсэн арга бол **Эрүүл мэндийн боловсрол /ЭМБ/** юм гэдгийг судлаачид нэгэн дуугаар баталдаг билээ [27].

Эрүүл мэндийн боловсролын ач холбогдолыг дэлхий дахинаа хүлээн зөвшөөрч, дэмжиж байгаагийн илрэл болох ДЭМБ, Олон улсын хүүхдийн фондоос хамтарч, 1978 оны 9-р сард ЗХУ-ын Алма-Ата хотноо “Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж” сэдвээр зохиосон олон улсын их хурлаас дэлхий дахины хүн амын эрүүл мэндийг хамгаалах эрхийг хангах, эрүүл мэндийн тусламжийг хүрэлцээтэй болгоход чиглэсэн баримт бичиг “Алма-Атагийн тунхаглал”-ыг баталсан билээ. Тунхаглалд “Эрүүл мэндийн анхны тусламж гэдэг ойлголтыг тусгаж, эхний элементэд “Зонхилон тохиолдох

эмгэгээс сэргийлэх бүрэн мэдлэгийг эзэмших хүн амын итгэл үнэмшилд нийцсэн эрүүл мэндийн боловсролын тогтолцоог бий болгох"-ыг заасан байна [27].

Эрүүл мэндийн боловсрол нь хүн амд эрүүл аж төрөх ёсны хүмүүжил төлөвшүүлэх үндсэн арга бөгөөд эмч хүний зайлшгүй гүйцэтгэх ёстой үндсэн үйл ажиллагааны нэг юм. Энэ үүднээс манай улсын засгийн газар 1999 онд “Амны Хөндийн Эрүүл Мэндийн Үндэсний Хөтөлбөр” [1], 2001 онд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 96-р тогтоолоор “Амны Хөндийн Эрүүл Мэндийн Нийслэлийн Дэд Хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байгаа билээ. Хөтөлбөрт АХЭМэндийн боловсролын талаар тусгайлан бүлэг болгон оруулж өгсөн бөгөөд үүнд: “Нийслэлийн хүүхэд залуучууд, нийт хүн амыг шүд, амны хөндийн эрүүл мэндээ хамгаалах эрүүл ахуйн дадал заншилтай болгоход чиглэгдсэн албан болон албан бус сургалтыг эрчимжүүлэх, агуулгыг нь баяжуулах” [1] хэмээн дурьдсан байна.

Нөгөө талаас орчин үеийн эрүүл мэндийн боловсрол, тэр дундаа шүд, амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгож байгаа аргууд нь олон төрлийн (шууд аргаар – сургалт, семинар, үзлэг зөвлөгөө, шууд бус аргаар – лекц, кино, радио телевизийн нэвтрүүлэг, өдөрлөг, жүжигчилсэн тоглолт, зөвлөмж, интернет зөвлөмж зэргээр) аргууд байдаг [27] бөгөөд шүд, амны хөндийн эрүүл мэндийн боловсролын агуулгыг баяжуулах, үр өгөөжийг нь дээшлүүлэх хэрэгтэй юм.

Мөн эрүүл мэндийн боловсролын үйл ажиллагааг явуулахдаа тухайн орны онцлог, хүн амын уламжлалт ёс заншил, боловсролд нь тохируулан олгох нь өндөр үр дүнтэйг ДЭМБ зөвлөдөг байна [12]. Энэ үүднээс авч үзвэл Монголчууд өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх арга ухааныг өвөг дээдсээсээ уламжлан өөрийн гэсэн сурган хүмүүжүүлэх арга барил,

амьдралын дэглэм, хүрээлэн буй орчин, өөрийн биемахбодийн өвөрмөц онцлогт тохируулан ёс заншил, идээ ундаа, явдал мөрөөрөө зохицуулан мөрдөж ирсэн онцлог туршлагатай ард түмэн юм. Эрүүл аж төрөх ёсны энэхүү уламжлалыг бид хотжилт, нүүдлийн мал аж ахуй хосолсон зах зээлийн өнөөгийн нөхцөлд тохируулан өвлөж авах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа билээ [12].

Монголчууд эрт үеэс эхлэн эрүүл чийрэг, тэр дундаа шүд сайтайгаараа гайхуулж ирсэнийг “...Монголчууд өглөө босч бие засахдаа шүдээ сайн зуудаг, Монголчуудын шүд бараг өвддөггүй байсан нь цагаан идээ иддэгийн ач тус юм...” [Кролайн Хэмфри, 1989; Цэрэн. Ц, 1991], “Нүүрний хэв маяг нь бусад хүмүүсээс ялгаатай. Хоёр нүд нь хоорондоо их зайтай, шанаагаараа өргөн, хацар нь гүрийсэн булчинтай, шүд сайтай, намхан хавтгай хамартай, онигор нүдтэй... малын сүүгээр хийсэн чулуу мэт өвөрмөц хатуу идээний зүйлийг ажрахгүй зажлан иднэ...” (Плано Карпини, XIII зуун.) [9] гэх зэргээр судлаачид бичиж тэмдэглэж байснаас нь харж болно.

Шүд нь сайн, шүдний талаархи өөрийн гэсэн тодорхой ойлголт, үнэлэмжүүдийг бага наснаас нь эхлэн ойлгуулж, өвлүүлэн сурталчилж, хэвшүүлж байсныг монгол ардын аман зохиол (оньсого таавар, зүйр цэцэн үгс, ардын дуу, ерөөл, магтаал)-д хэрхэн тусгасныг судлаж нэгтгэн дүгнэснээрээ нэг талаас танин мэдэхүйн болон практикийн нөгөө төлөөс Монголын гэсэн тодотголтой амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох цаашид хөгжүүлэн дэлгэрүүлэх, хойч үеийг өвөг дээдсийнхээ бий болгосон соёлын өвөөр бахархах хүмүүжлийг олгоход ач холбогдолтой гэж үзлээ.

Номзүй:

1. Амны хөндийн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр. УБ, 1999.
2. “Анагаах арга билиг” сонин. №5. 2002.
3. Агваандондов. Ш, “Монгол хар домгийн судрын чуулган”. Улаанбаатар хот. 1991. Х15-16
4. Аким. Г, “Монгол зүйр цэцэн үгийн товч тайлбар толь”. Улаанбаатар хот. 2001. 185х.
5. Ариунхишиг. Ц, Цолмон. Х, “Шүд хоршихуй ба нэршил зүй”. Улаанбаатар хот. 1998. 25х. 3-5
6. Арслан. Я, “Мянган өвчнийг өөрөө анагаах арга билиг”. Улаанбаатар хот. 1993.
7. Бат-Ирээдүй. Ж, Аким. Г, “Зүйр цэцэн үгийн зүйлээр хуваасан толь”. Улаанбаатар хот. 2005. 176х.
8. Баавгай. Ч, Болдсайхан. Б, “Монголын уламжлалт анагаах ухаан”. Улаанбаатар хот. 1990. 211, 218, 238, 312
9. Баттогтох. Д, “Уламжлалт сурган хүмүүжлийн лекцүүд”. Улаанбаатар хот. 2006. 12х,
10. Галсан. Т, “Монгол ертөнцийн гурав”. Улаанбаатар хот. 2005. 530х.
11. Гадамба буюу Бурхан багш Шагжамүни “Цог төгөлдөр дөрвөн үндэс”.
12. Дагвацэрэн. Б, Батчимэг. Ө, Варламова. Т. С, Наранцэцэг. Г, “Өвчнөөс сэргийлэх уламжлалт анагаах ухааны ёс”. Улаанбаатар хот. 2003. 204х.
13. Долгорсүрэн. Ж, “Монгол аман соёлын онцлог”. Улаанбаатар хот. 2002. 100х.

14. Жачин. Ч, Долзодмаа. С, “Түмэн оньсого тайлах түлхүүр: хүүхдийн цэцэрлэг, бага ангийн багш, эцэг эхчүүдэд зориулав”. Улаанбаатар хот. 2000. 83х.
15. Жигмэд. Ч, “Ерөөл магтаалууд”. Улаанбаатар хот. 1990. 38х.
16. Ловор. Г, Өлзийхутаг. Ц, Цэрэнсодном. Д, “Монгол ардын оньсого таавар”. Улаанбаатар хот. 1990. 334х.
17. Ловор. Г, Өлзийхутаг. Ц, Цэрэнсодном. Д, “Монгол ардын оньсого”. Улаанбаатар хот. 1999. 338х.
18. Мухар. Ц, “Монголын эрүүлийг хамгаалах: түүх, соёл иргэншил, ёс зүй”. Улаанбаатар хот. 2006. 5-20.
19. МУИС. Монгол Судлалын Сургууль, Эх бичиг Алтай судлалын тэнхим, “Монгол зүйр цэцэн үгийн 3000 дээж”. Улаанбаатар хот. 1999. 177х.
20. Нацагдорж. Ц, Монголын нууц товчоо.
21. Номин. “Зохист толь”. Улаанбаатар хот. 1996. 83х.
22. Одонтуяа. Л, “Монголын зүйр цэцэн үгэнд үнэлэмж илрэх онцлог”. Улаанбаатар хот. 2004. 112х. 49-51.
23. Өлзийхутаг. Ц, “Монгол ардын ерөөл магтаал”. Улаанбаатар хот. 1989. 90х.
24. Өлзийхутаг. Ц, “Монгол ардын оньсого”. 7 боть. Улаанбаатар хот. 1989. 142х.
25. Өлзийхутаг. Ц, “Түмэн оньсого”. Улаанбаатар хот. 1989.
26. Пүрэвжав. Н, “Зажилж идвэл хоол, залгиж идвэл хор”. Улаанбаатар хот. 1997.
27. Цэрэнжигмэд. Г, “Эрүүл мэндийн боловсрол”. Улаанбаатар хот. 2004 он. 96х. 1-4; 49-57

28. Цэрэнжигмэд. Г, “Ариун цэврийн соёл, түүний уламжлал шинэчлэлийн зарим асуудалд”. Улаанбаатар хот. 1997. 78х.
29. Цэрэнсодном. Д, Цэдэв. Д, “Монгол ертөнцийн гурав”. Улаанбаатар хот. 2002. 92х.
30. Хорлоо.П, “Монголын аман зохиол дахь ардын сурган хүмүүжүүлэх ухаан”. Улаанбаатар хот. 2002. 117х.
31. Хорлоо.П, Сампилдэндэв. Х, “Монгол аман зохиол дахь гоо сайхны сэтгэлгээ”. Улаанбаатар хот. 2001. 124х.
32. Сампилдэндэв. Х, Гаадамба. Ш, “Монгол аман зохиол”. Улаанбаатар хот. 2006.
33. Сампилдэндэв. Х, “Монгол ардын сурган хүмүүжүүлэх зүйн туршлага: Аман зохиолын жишээн дээр”. Улаанбаатар хот. 2005. 220х.
34. Шагдар. Ш, “Монгол улсын боловсролын түүхийн товчоон”. Улаанбаатар хот. 2000.
35. Шагдарсүрэн. А, “Монгол ардын зүйр цэцэн үг”. 1-р боть. Улаанбаатар хот. 2005. 123х.
36. Шагдарсүрэн. А, “Монгол ардын зүйр цэцэн үг”. 2-р боть. Улаанбаатар хот. 2005. 165х.
37. Эрдэнэ-Очир. Г, “Монгол ардын сурган хүмүүжүүлэх уламжлал, түүний хөгжил”. Улаанбаатар хот. 1993. 117х. 4-12; 28; 47; 49; 99-100; 120; 121; 124-125.
38. Эрдэнэ-Очир. Б, “Ерөнхий боловсролын бага ангийн (1-3) сурагчдын хэл ярианы хөгжлийн бэрхшээлийг засах боломжийг судалсан нь”. 2005. 121х.

**39. Пүрэвжав. Н, “Функционально-эстетические основы
ортопедического лечения при полной утрате зубов”.**

Автореф.дисс.канд.мед.наук.-Москва, 1989. 8-16.